



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2022 оны 08 сарын 26 өдөр

Дугаар 14

Улаанбаатар хот

Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн 2022 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн 14 дүгээр хуралдааны тэмдэглэлд:

“3. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар нийслэлийн холбогдох байгууллагуудын удирдлагуудын хамт 2022 оны 06 дугаар сарын 28-ны өдөр “Шинэ Улаанбаатар баруун терминал” цогцолбор төсөл хэрэгжих талбайд ажиллаж уг төслийг Драгон Холдинг ХХК-тай хамтран төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэхээр үүрэг болгосон талаар Улаанбаатар хотын хөгжлийн корпораци ХК-ийн Гүйцэтгэх захирал Н.Баярчимэг танилцуулав.

Энэ асуудалтай холбогдуулан:

1. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 02/09, 02/10 дугаар тогтоол, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон “Драгон Холдинг” ХХК-ийн хооронд 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдөр байгуулсан 01/03 тоот хамтын ажиллагааны Санамж бичгийн дагуу Баянгол дүүргийн 20 дугаар хороо, Сонгинохайрхан дүүргийн 29 дүгээр хороо, Хан-Уул дүүргийн 5 дугаар хороодын нутаг дэвсгэрт хэрэгжих “Шинэ Улаанбаатар баруун терминал” цогцолборын барилга, Яармаг дэд төвийг Баянхошуу дэд төвтэй босоо тэнхлэгээр холбох “Ногоон өргөн чөлөө бүхий 5.5 км авто зам, замын байгууламж”, Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит “Ард түмний цэцэрлэгт хүрээлэн” бүхий цогцолбор төслийг төр, хувийн хэвшлийн түншлэл, концессоор хэрэгжүүлэхийг Улаанбаатар хотын хөгжлийн корпораци ХК /Н.Баярчимэг/-д;

2. Дээрх байршлуудад Архитектур төлөвлөлтийн даалгаврыг батлахыг Нийслэлийн ерөнхий архитектор /Н.Нацагдорж/-д;

3. Төсөл хэрэгжүүлэхтэй холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 2019 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн А/282 дугаар захирамжийн хавсралт “Хот байгуулалт, хөгжлийн газрын дүрэм”-ийн 3 дахь хэсэгт заасан чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг Хот байгуулалт, хөгжлийн газар /Ц.Тулга/-т;

4. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 35 дугаар тогтоолын хавсралт “Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх төлөвлөгөө 2016-2030”-д заасны дагуу төсөлд шаардлагатай чиг үүргийг хэрэгжүүлж, дэмжлэг үзүүлэн ажиллахыг Нийслэлийн Байгаль орчны газар /М.Нямбаяр/-т;

111020000086

5. Шинэ Улаанбаатар баруун терминал цогцолбор төслийн бүтээн байгуулалтын ажлыг стандартын дагуу гүйцэтгүүлж, Монгол Улсын барилгын норм ба дүрмийн дагуу стандартын шаардлага хангасан барилга байгуулалмжийг ашиглалтад оруулах үйл ажиллагааг дүрмийн дагуу зохион байгуулж, ажиллуулахыг Хотын стандарт, хяналтын газар /С.Төмөрдулам/-т;

6. Цогцолбор төслийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор инженерийн шугам сүлжээ, автозамын зураг төсөл зөвшилцөх, төсөл хэрэгжүүлэх бүсэд шаардлагатай газар чөлөөлөлт, газрын өмчлөл эзэмшлийн асуудлыг хуулийн дагуу шийдвэрлэж ажиллахыг Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба /Г.Батзориг/-нд;

7. Төслийн хүрээнд авто зам, замын байгууламжийг шинээр барих, өргөтгөн шинэчлэх ажлын хүрээнд хяналт тавих, зураг төсөлд санал өгөх, инженерийн шугам сүлжээ, орц, гарц, авто зогсоол шинээр хийх, өргөтгөл шинэчлэлтийн ажилтай холбогдуулан иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудтай зөвшилцөх, зөвшөөрөл олгон ажиллахыг нийслэлийн Замын хөгжлийн газрын хэлтсүүдэд даалган ажиллахыг Нийслэлийн Замын хөгжлийн газар /Г.Баярсайхан/-т;

8. Ундны усны эх үүсвэрийн эрүүл ахуйн хориглолтын бүсийн Мах комбинатын эх үүсвэр, Үйлдвэрийн эх үүсвэрийн хэсэгт Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит цэцэрлэгт хүрээлэн байгуулах, авто замын трассыг тодорхойлох ажилд дэмжлэг үзүүлж, хамтран хэрэгжүүлэхийг Ус сувгийн удирдах газар /Ц.Төрхүү/-т;

9. Цогцолбор төслийг хэрэгжүүлэх явцад төсөл хэрэгжүүлэх газрын аюулгүй байдлын талаар дүгнэлт, холбогдох бусад зөвшөөрлийг гарган ажиллахыг Нийслэлийн Онцгой байдлын газар / А.Дашням/-т;

10. Төслийг дэмжиж, хамтран ажиллахыг Сонгинохайрхан дүүргийн Засаг дарга /Н.Алтаншагай/, Хан-Уул дүүргийн Засаг дарга /Ж.Алдаржавхлан/, Баянгол дүүргийн Засаг дарга /Ө.Сумъяабаатар/ нарт;

11. Төсөл хэрэгжүүлэхтэй холбоотой ажил үүргийг нэгдсэн удирдлагаар хангаж, ажлын явц, хэрэгжилтийг тогтмол танилцуулж ажиллахыг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба /Д.Ганболд/-нд тус тус үүрэг болгов” гэжээ.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

